

Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Эрүүл мэндийн сайдын 2023 оны
.... дугаар сарын - ны өдрийн/....
дугаар хамтарсан тушаалын хавсралт

СЭТГЭЦИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ (цаашид “шинжилгээ” гэх) хийхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Шинжилгээ хийхэд Шүүх шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шидвэрлэх тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандарт болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр.Шинжилгээ хийхэд тавигдах нийтлэг шаардлага

2.1.Шинжилгээг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн сэтгэцийн эмгэг судлаач мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан сэтгэцийн мэргэжлийн 2-оос доошгүй шинжээч эмч хийнэ. Шаардлагатай гэж үзвэл шинжилгээнд төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг оролцуулах хүсэлтийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргана.

2.2.Шинжилгээний дүгнэлтийг шинжлүүлэгчид хийсэн үзлэг, шинжилгээ болон урьд эмчлүүлж, шинжлүүлж байсан эмнэлгийн баримт бичиг зэргийг үндэслэн гаргана.

2.3.Шинжилгээ хийлгэх шийдвэрийг хавтаст хэргийн материал, өвчний түүх болон бусад шаардлагатай баримт материалын хамт ирүүлнэ.

2.4.Анхдагч, нэмэлт болон дахин шинжилгээний дүгнэлтүүд зөрүүтэй гарсан тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын багийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд томилж, дүгнэлт гаргуулж болно.

2.5.Эрүүл мэндийн байгууллага шинжлүүлэгчийн өвчний түүх, бусад шаардлагатай баримт материалыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд саадгүй гаргаж өгөх ба төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг хийх үүрэг хүлээнэ.

2.6.Шинжлүүлэгчийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад байрлуулж, шинжилгээг хийж болно.

Гурав.Шинжилгээ хийх шинжээч эмчийн эрх, үүрэг

3.1.Шинжээч эмч Шүүх шинжилгээний тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2.Шинжээч эмч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрт тусгагдсан асуулт тус бүрд шинжлэх ухааны үндэслэл бүхий хариулт өгч, дүгнэлт гаргана.

Дөрөв.Шинжилгээний хийх хэлбэрүүд

4.1.Шинжилгээг дараах хэлбэрээр хийнэ:

4.1.1.амбулаториор хийгдэх сэтгэцийн шинжилгээ;

4.1.2.стационараар хийх сэтгэцийн шинжилгээ;

4.1.3.нас барсны дараа хийх сэтгэцийн шинжилгээ.

4.2.Шинжилгээг амбулаторийн хэлбэрээр шинжээчдийн баг хийнэ.

4.3.Сэтгэцийн шинжээчдийн баг шинжлүүлэгчийн сэтгэцийн байдлыг амбулаториор тогтоох боломжгүй тохиолдолд стационарт хэвтүүлэн шинжилгээ хийнэ.

4.4.Стационараар шинжлүүлэгчийн сэтгэцийн байдлыг харгалзан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиник болон бусад сэтгэцийн эмгэг судлалын клиникт, орон нутагт аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагт хэвтүүлж онош тогтоон дүгнэлт гаргана.

4.5.Хэрэв шинжлүүлэгчийн сэтгэцийн байдал нийгэмд онц аюултай, оргох, дахин гэмт хэрэг үйлдэх зэрэг эрсдэлтэй бол сэтгэцийн эмгэгийн харуул хамгаалалттай клиник тасагт байрлуулж шинжилгээ хийнэ. Энэ тохиолдолд харуул хамгаалалтыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд хариуцна.

4.6.Нас барсны дараах шинжилгээг шинжээчдийн баг хэргийн материал болон эмнэлгийн баримтуудыг үндэслэн хийнэ.

4.7.Нас барсны дараах сэтгэцийн шинжилгээг хийхэд хэргийн материалд сэтгэцийн талаар материал хангалтгүй байвал шинжээч Шүүх шинжилгээний тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.3-т заасныг үндэслэн нэмэлт материал хүсэх эрхтэй бөгөөд мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6-т заасныг үндэслэн шинжилгээ хийхээс татгалзаж болно.

Тав.Иргэний хэрэгт сэтгэцийн шинжилгээ хийх

5.1.Хэлцэл хийх, бэлэглэл, гэрээслэл, өв залгамжлах эрх үүсэх, гэр бүл болох, гэр бүл салах зэрэг иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч нь сэтгэцийн эмгэгтэй байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдвол иргэний эрх зүйн чадамжтай эсэхийг тогтоож болно.

Зургаа.Бусад

6.1.Шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад батлагдсан хэвлэмэл хуудас, маягт, хувийн тэмдэг хэрэглэнэ.

6.2.Шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийсэн шинжээч нарт ажлын хөлсийг тогтоосон тарифаар шинжлүүлэгчээс гаргуулан олгоно.

6.3.Орон нутагт томилолтоор шинжилгээ хийсэн тохиолдолд томилолтын зардлыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд хариуцна.

6.4.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---